

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт зөрчилд	17
Залруулсан алдаа	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал	19
1. Бараа материалын данстай холбоотой асуудал	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Г.МАНЛАЙЖАВ ТАНАА

2021.02.25 № 07/495
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд 20 зорилт, 50 арга хэмжээ, Стратеги төлөвлөгөө, чиг үүрэг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд 5 зорилт, 5 арга хэмжээ, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 7 зорилт, 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>206,757,543.49</u>	<u>184,360,755.08</u>
33	АВЛАГА	49,988,494.07	35,255,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	49,840,000.00	35,255,000.00
3351	Байгууллагаас авах авлага	148,494.07	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	156,769,049.42	149,105,755.08
351	Түүхий эд материал	47,131,964.27	45,910,418.19
35110	Тусгай зориулалттай материал	47,131,964.27	45,910,418.19
354	Хангамжийн материал	109,637,085.15	103,195,336.89
35410	Бичиг хэргийн материал	10,803,451.00	8,985,351.00
35420	Аж ахуйн материал	9,753,377.00	8,148,164.00
35440	Түлш, шатах тослох материал	8,319,482.95	8,444,862.95
35470	Бусад хангамжийн материал	80,760,774.20	77,616,958.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,079,435,856.37</u>	<u>3,919,634,359.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,079,435,856.37	3,919,634,359.74
392	Биет хөрөнгө	2,974,828,862.75	2,816,235,171.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,100,543,041.38	2,100,543,041.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	-86,347,218.36	-172,694,436.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	155,828,000.00	155,828,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-150,378,000.00	-153,228,000.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,532,075,531.39	1,536,012,817.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-598,097,361.45	-655,857,595.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,299,353.60	86,284,253.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-85,662,693.27	-86,032,353.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	108,375,085.60	108,375,085.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-87,806,876.14	-102,995,640.54
393	Биет бус хөрөнгө	1,104,606,993.62	1,103,399,188.10
39301	Программ хангамж	25,759,027.60	25,759,027.60
39302	Хуримтлагдсан элэгдэл	-21,028,455.98	-22,236,261.50
39303	Бусад биет бус хөрөнгө	1,099,876,422.00	1,099,876,422.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,286,193,399.86</u>	<u>4,103,995,114.82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,620,058.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,620,058.00	00.00
4136	Бусад өглөг	1,620,058.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,620,058.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,284,573,341.86</u>	<u>4,103,995,114.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,284,573,341.86	4,103,995,114.82
511	Засгийн газрын оруулсан капитал	1,099,876,422.00	1,099,876,422.00
51101	Өмч: - төрийн	1,099,876,422.00	1,099,876,422.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,547,536,103.31	1,366,957,876.27
51210	Өмнөх үеийн үр дүн	1,547,536,103.31	1,547,536,103.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-180,578,227.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,637,160,816.55	1,637,160,816.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,286,193,399.86</u>	<u>4,103,995,114.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,827,340,895.56	1,363,701,262.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,940,795.56	91,344,662.00
120	Нийтлэг татварын бус орлого	98,940,795.56	91,344,662.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,940,795.56	91,344,662.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,424,550.00	32,280,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,516,245.56	59,063,862.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,728,400,100.00	1,272,356,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	162,095,733.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	162,095,733.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	1,566,304,367.00	1,272,356,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,566,304,367.00	1,272,356,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,866,479,126.01	1,544,279,489.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,866,479,126.01	1,544,279,489.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,330,582,818.71	933,595,928.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,991,961.20	445,790,911.60
210101	Үндсэн цалин	426,991,961.20	325,725,398.12
210102	Нэмэгдэл	00.00	93,941,563.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	26,123,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,676,085.26	59,857,545.92
210201	Тэтгэврийн даатгал	39,074,034.26	42,706,501.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,232,486.00	3,877,410.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,385,989.00	4,888,773.08
210204	Ажилгүйдлийн даатгал	816,689.00	762,332.89
210205	Эрүүл мэндийн даатгал	8,166,887.00	7,622,527.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,549,989.02	49,652,993.13
210301	Гэрэл, цахилгаан	16,437,608.00	26,316,492.00
210302	Түлш, халаалт	6,844,256.50	9,265,440.98
210303	Цэвэр, бохир ус	2,240,124.52	1,467,060.15
210304	Байрны түрээс	11,028,000.00	12,604,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,067,668.75	55,456,693.79
210401	Бичиг хэрэг	11,809,681.50	8,804,640.00
210402	Тээвэр, шатахуун	9,259,179.00	7,233,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,579,060.55	11,877,691.45
210404	Ном, хэвлэл	3,782,100.00	1,944,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,205,000.00	1,609,834.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,406,963.70	23,986,208.34
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	25,684.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	289,889,346.00	9,890,537.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	470,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,450,760.00	9,420,537.00
210604	Урсгал засвар	287,438,586.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	13,762,643.00	24,600.00
210702	Дотоод албан томилолт	1,221,000.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	12,541,643.00	24,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	243,051,160.60	80,502,788.00

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,052,791.60	64,253,700.00
n210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,815,726.00	3,142,776.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,800.00	20,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,200.00	100,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,606,250.00	4,336,700.00
210807	Газрын төлбөр	7,707,100.00	7,202,852.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,372,293.00	1,445,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	207,593,964.88	232,419,858.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,241,000.00	1,453,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	205,352,964.88	230,966,358.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	535,896,307.30	610,683,560.97
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	478,465,977.00	478,466,648.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	478,465,977.00	478,466,648.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,250,440.00	22,607,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,250,440.00	4,928,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,678,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,179,890.30	109,609,412.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,179,890.30	109,609,412.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-39,138,230.45	-180,578,227.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,817,115.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,817,115.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,817,115.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-45,955,345.45	-180,578,227.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,771,631,800.00</u>	<u>1,319,222,400.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,231,700.00	46,865,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,231,700.00	46,865,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,231,700.00	46,865,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,231,700.00	46,865,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,728,400,100.00	1,272,356,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	162,095,733.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	162,095,733.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	1,566,304,367.00	1,272,356,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,566,304,367.00	1,272,356,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,771,631,800.00</u>	<u>1,319,222,400.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,771,631,800.00	1,319,222,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,235,216,092.70	708,538,839.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,590,300.00	447,262,475.53
210101	Үндсэн цалин	319,530,800.00	320,887,254.05
210102	Нэмэгдэл	77,961,100.00	100,210,221.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,098,400.00	26,165,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,355,700.00	59,857,545.92
210201	Тэтгэврийн даатгал	53,355,700.00	42,706,501.53
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,877,410.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	4,888,773.15
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	762,332.89
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	7,622,528.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,549,989.02	49,652,993.13
210301	Гэрэл, цахилгаан	16,437,608.00	26,316,492.00
210302	Түлш, халаалт	6,844,256.50	9,265,440.98
210303	Цэвэр, бохир ус	2,240,124.52	1,467,060.15
210304	Байрны түрээс	11,028,000.00	12,604,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,429,738.55	34,421,099.45
210401	Бичиг хэрэг	6,009,450.00	6,526,490.00
210402	Тээвэр, шатахуун	9,927,600.00	7,358,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,579,060.55	11,877,691.45
210404	Ном, хэвлэл	4,054,900.00	1,944,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,006,700.00	3,165,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,852,028.00	3,548,018.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	406,629,556.00	30,500,037.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	97,843,700.00	17,180,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,432,300.00	13,320,037.00
210604	Урсгал засвар	287,353,556.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	15,240,956.00	00.00

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	1,907,324.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	13,333,632.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	272,169,853.13	85,391,188.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	241,577,734.13	64,253,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,815,726.00	3,142,776.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,800.00	20,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,200.00	100,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,200,000.00	9,225,100.00
210807	Газрын төлбөр	7,707,100.00	7,202,852.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,372,293.00	1,445,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,250,000.00	1,453,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	1,453,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	536,415,707.30	610,683,560.97
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	478,465,977.00	478,466,648.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	478,465,977.00	478,466,648.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,769,840.00	22,607,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,769,840.00	4,928,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,678,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	109,609,412.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	109,609,412.97
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	47,179,890.30	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,179,890.30	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	48,031,301.57	1,190,508,177.00	1,238,539,478.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	48,031,301.57	1,190,508,177.00	1,238,539,478.57
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	402,983,271.76	402,983,271.76
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,099,876,422.00	1,637,160,816.55	1,547,536,103.31	4,284,573,341.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,099,876,422.00	1,637,160,816.55	1,547,536,103.31	4,284,573,341.86
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-180,578,227.04	-180,578,227.04
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,099,876,422.00	1,637,160,816.55	1,366,957,876.27	4,103,995,114.82

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,345,612,700.00	1,209,612,987.03	135,999,712.97	89.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,345,612,700.00	1,209,612,987.03	135,999,712.97	89.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	844,536,900.00	708,538,839.03	135,998,060.97	83.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	447,506,300.00	447,262,475.53	243,824.47	99.9
210101	Үндсэн цалин	323,446,300.00	320,887,254.05	2,559,045.95	99.2
210102	Нэмэгдэл	99,862,200.00	100,210,221.48	-348,021.48	100.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,197,800.00	26,165,000.00	-1,967,200.00	108.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,413,400.00	59,857,545.92	555,854.08	99.1
210201	Тэтгэврийн даатгал	42,513,100.00	42,706,501.53	-193,401.53	100.5
210202	Тэтгэмжийн даатгал	4,475,100.00	3,877,410.24	597,689.76	86.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,580,000.00	4,888,773.15	-1,308,773.15	136.6
210204	Ажилгүйдлийн даатгал	895,000.00	762,332.89	132,667.11	85.2
210205	Эрүүл мэндийн даатгал	8,950,200.00	7,622,528.11	1,327,671.89	85.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,667,900.00	49,652,993.13	2,014,906.87	96.1
210301	Гэрэл, цахилгаан	25,263,100.00	26,316,492.00	-1,053,392.00	104.2
210302	Түлш, халаалт	11,532,300.00	9,265,440.98	2,266,859.02	80.3
210303	Цэвэр, бохир ус	2,268,500.00	1,467,060.15	801,439.85	64.7
210304	Байрны түрээс	12,604,000.00	12,604,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	34,585,000.00	34,421,099.45	163,900.55	99.5
210401	Бичиг хэрэг	6,526,500.00	6,526,490.00	10.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	7,358,900.00	7,358,900.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,035,100.00	11,877,691.45	157,408.55	98.7
210404	Ном, хэвлэл	1,944,800.00	1,944,800.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,165,200.00	3,165,200.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,554,500.00	3,548,018.00	6,482.00	99.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,592,200.00	30,500,037.00	53,092,163.00	36.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	70,272,100.00	17,180,000.00	53,092,100.00	24.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,320,100.00	13,320,037.00	63.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,691,500.00	0	3,691,500.00	0.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,691,500.00	0	3,691,500.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161,627,100.00	85,391,188.00	76,235,912.00	52.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	137,509,800.00	64,253,700.00	73,256,100.00	46.7
210803	Даатгалын үйлчилгээ	3,819,600.00	3,142,776.00	676,824.00	82.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	401,800.00	20,800.00	381,000.00	5.2

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,200.00	100,200.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,231,200.00	9,225,100.00	6,100.00	99.9
210807	Газрын төлбөр	7,707,100.00	7,202,852.00	504,248.00	93.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,857,400.00	1,445,760.00	1,411,640.00	50.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1453500	1453500	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,453,500.00	1,453,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	501075800	501074148	1,652.00	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	478,468,300.00	478,466,648.00	1,652.00	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	478,468,300.00	478,466,648.00	1,652.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,607,500.00	22,607,500.00	0.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,928,800.00	4,928,800.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,678,700.00	17,678,700.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,345,612,700.00	1,319,222,400.00	26,390,300.00	98.0
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,345,612,700.00	1,272,356,600.00	73,256,100.00	98.0
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,345,612,700.00	1,272,356,600.00	73,256,100.00	98.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	46,865,800.00	-46,865,800.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	46,865,800.00	-46,865,800.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	33	33	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	32	32	0	100.0

Жич: 2020 онд үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдаагүй болно.

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Г. Манлайжав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалыг зөв ангилан бүртгэх, байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, дансны төлөвлөгөө зэрэг эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын аудитын газрын захиалгаар Ол дөш хайрхан аудит ХХК-ийн ахлах аудитор Т. Сарантуяа хянан удирдаж, аудитор Ц. Бумцэнд, аудиторын туслах С. Хажид нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ол дөш хайрхан аудит ХХК-д 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 1/42 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрхэм зорилгоо “Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийг бэлтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

2. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журмыг батлах;

3. Ураны баяжмал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн онцлогийг харгалзан түүний хүчин чадал, тоо хэмжээ, шилжилт хөдөлгөөн, тээвэрлэлтийн холбогдолтой нууцлах мэдээллийн жагсаалтыг баталж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;

4. Цацраг идэвхт ашигт малтмалын болон цөмийн энергийн салбарт хамтран ажиллах стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, тэдэнтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах асуудлаар санал, дүгнэлт гаргах;

5. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах асуудлаар холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны

байгууллагын удирдлагад үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд хяналт тавих;

6. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, цацрагийн ослын хор уршгийг арилгах талаар яаралтай авах арга хэмжээний талаарх саналыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;

7. Эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, геологи, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэр, байгаль орчин, боловсрол, шинжлэх ухааны салбарт цөмийн технологи нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

8. Цөмийн болон цацраг идэвхт хаягдал, цацрагийн үүсгүүрийг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд ашиглаж байгаа ионжуулагч цацраг бүртгэх багаж, тоног төхөөрөмжийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, тохируулга хийх;

9. Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах болон цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах эрхийн тусгай зөвшөөрөл олгох, түүнчлэн цацраг идэвхт ашигт малтмал болон цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлд санал өгөх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогод зарим өөрчлөлтүүдийг оруулсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн баталсан байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Ажлын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлын 1,209,612.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон, 12,096.1 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Цөмийн энергийн комиссын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 182,198.2 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	49,988.5	35,255.0	-14,734.0
Бараа материал	156,769.0	149,105.8	-7,663.2
Үндсэн хөрөнгө	4,079,495.8	3,919,634.3	-159,861.5
Нийт хөрөнгө	4,286,193.3	4,103,995.1	-182,198.2
Өр төлбөр	1,620.0		-1,620.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,099,876.4	1,099,876.4	0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,637,160.8	1,637,160.8	
Хуримтлагдсан үр дүн	1,547,536.1	1,366,957.9	-180,578.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,286,193.3	4,103,995.1	-182,198.2

Авлага дансны үлдэгдэл 35,255.0 мянган төгрөг болж, 14,734.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд авлага үүсээгүй, авлага барагдуулах арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлснээс шалтгаалсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 149,105.7 мянган төгрөг болж, 7,663.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд Ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор төсвийн санхүүжилт буурсан,

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,919,634.3 мянган төгрөг болж, 159,861.5 мянган төгрөгөөр буурсан нь 16,380.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй шилжүүлсэн, 50,862.1 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталсан, тайлант онд 230,966.3 мянган төгрөгөөр элэгдлийн зардал байгуулсан зэрэг нь тус тус нөлөөлжээ.

Өр төлбөр данс үлдэгдэлгүй болж, 1,620.0 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулжээ.

Засгийн газрын оролцоо дансны 1,099,876.4 мянган төгрөгийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт төсвийн санхүүжилт үйл ажиллагааны орлого өмнөх оноос 463,639.6 мянган төгрөгөөр буюу 25 хувиар буурсан нь Ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан тэвчиж болох зардлыг бууруулснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 514,838.9 мянган төгрөгөөр буюу 30 хувиар буурсан нь Ковид-19 цар тахал өвчний улмаас төсвийн санхүүжилт болон тэвчиж болох зардлыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс эд хогшил, урсгал засварын зардал 376,129.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 186,778.7 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 9,182,858.9 мянган төгрөг, үүнээс хөрөнгө оруулалт нь 2,804,979.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 7,837,246.2 мянган төгрөгөөр бууруулж, 1,345,612.7 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс материаллаг өөрчлөлттэй байгаа нь сүүлийн арваад жил ямар нэгэн хөрөнгө оруулалт хийдээгүй, ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмж хуучирч муудсан, тусгай зориулалтын тоног төхөөрөмжүүдийг бэлтгэх шаардлага гарч байгаа, зарим нэрийн зардлууд хүрэлцэхгүй байгаа зэрэгтэй холбоотой байна.

Тухайлбал: төсвийн урсгал зардал болох төрийн албан хаагчийн ажлын үр дүнгээр олгодог зарим нэмэгдлүүдийг олгоход 125,572.9 мянга, багаж техник хэрэгсэл худалдан авах, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэглэл авахад 3,924,335.2 мянга, БҮТЭЗ бэлтгэхэд 9,214.3 мянга, гадаад томилолтын зардалд 86,443.9 мянга, газрын төлбөрт 121,568.3 мянга, Олон улсын гишүүнчлэлийн татвар 773,215.1 мянган төгрөг зарцуулахаар төсөв төлөвлөгөөндөө тусгасан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд 20 зорилт, 50 арга хэмжээ, Стратеги төлөвлөгөө, чиг үүрэг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд 5 зорилт, 5 арга хэмжээ, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 7 зорилт, 32 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,345,612.7 мянган төгрөгийн зардлын төсөв батлагдсан байна.

Энэхүү зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,272,356.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 46,865.8 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоор бүрдүүлжээ. Үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө гэж баталдаггүй бөгөөд энэхүү орлого нь төсөвт буцаан татагддаг байна.

Гүйцэтгэлээр 1,319,222.4 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 1,209,612.9 мянган төгрөгийг зарцуулж, 109,609.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,209,612.9 мянган төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь эд хогшил, урсгал засварын зардал 53,092.2 мянга, томилолт, зочны зардлыг 3,691.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 76,235.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал өвчний улмаас тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой байна.

Үүнээс гадна тайлант онд цалингийн нэмэгдэл 348.0 мянга, унаа болон бусад нөхөн олговор 1,967.2 мянга, гэрэл цахилгааны зардал 1,053.4 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс илүү зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 134-р тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5 дугаар бүлгийн “Зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх хязгаар” гэсэн заалтад нийцэж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын төсвийн тухай хуульд зааснаар тухайн онд улсын төсөвт орлого төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдаагүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Гэвч Цөмийн энергийн комиссын ажлын алба тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 151 мэдээллээс санхүүгийн тайлангаа хугацаа хоцроож, 5.0 сая төгрөгөөс дээш дүн бүхий гүйлгээний мэдээллийг дутуу, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмж бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3		-	-	
Нийт дүн	3	-	3		-	-	

3.9. Аудитын илрүүлэлт зөрчилд

Аудитаар нийт 197,896.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 195,755.0 мянган төгрөгийн алдааг залруулж, Шилэн дансны хууль зөрчсөн зөрчилд албан шаардлага хүргүүлэх, 2,141.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг тус тус өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.”,15.2. “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.” гэсэн заалтуудыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж, залруулга хийлгэж баталгаажуулав. Үүнд:

1. Жилийн эцсийн санхүүгийн тайлант шалгахад мөнгөн гүйлгээний дүн 12,030.0 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчил илэрснийг залруулга хийлгэлээ.

2. Авлага дансны журналаарх гүйлгээний болон үлдэгдэл дүнг санхүүгийн байдлын тайлан, тодруулга, тооцоо хийсэн актын дүнтэй тулган шалгахад Жи И Энд Эс ХХК-тай хамаарал бүхий авлагын оны эхний үлдэгдэл 11,600.0 мянган төгрөгийг дутуу бүртгэснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.
3. Орлого, зарлагын журналаарх дүнг мөнгөн гүйлгээний тайлангаарх дүнтэй тулган шалгахад орлого 84,512.8 мянга, зарлага 81,055.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн программ хангамж алдаатай татагдаж байгаатай холбоотой учир, программ хангамжийн мэргэжилтнүүдтэй холбогдож, засуулах арга хэмжээ авч залруулга хийлгэлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 2020 онд шилэн дансанд байршуулсан мэдээллүүдийг нягтлан шалгахад Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд байршуулах 151 мэдээллээс санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 гүйлгээг байршуулаагүй, жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаа хоцроон байршуулсан зэрэг зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.2-д "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэсэн заалтуудыг тус тус бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг хугацаанд бүрэн байршуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2,141.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Тайлант оны аудитаар илэрч залруулсан алдаа зөрчлүүд нь программ хангамжтай холбоотой байсан бөгөөд цаашид нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж, гаргах аргачлал, үйлчлүүлэгч байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны төлөвлөгөөний дагуу хөрөнгийг зөв ангилан бүртгээгүй 2,141.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.
- 1.2. Эрсдэл: Бараа материалыг буруу ангилан бүртгэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;
- 1.3. Өгсөн зөвлөмж: Бараа материалыг зөв ангилан бүртгэх байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, дансны төлөвлөгөө зэрэг эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангаж алдаа зөрчил гаргахгүй байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх албан шаардлага болон зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			САГ-2021-6-СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цөмийн энергийн комиссын ажлын алба		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2020 оны ажил гүйлгээнээс 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил гүйлгээг шилэн дансанд байршуулсан гүйлгээтэй тулган шалгахад зарим ажил гүйлгээг дутуу, санхүүгийн тайланг 3 хоног хоцроон байршуулсан, аудитын дүгнэлт тайланг, хандив тусламжтай холбоотой зарим мэдээллийг байршуулаагүй.		Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Г. Манлайжав Н. Нямдулам
2	Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж, гаргах аргачлал, байгууллагын НББ-ийн бодлого, дансны төлөвлөгөөний дагуу хөрөнгийг зөв ангилан бүртгээгүй 2,141.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.	2,141.9	зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Г. Манлайжав Н. Нямдулам
ДҮН		2,141.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 133/АО160062
САН-2001/16/СТА-ТЦЗ
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудсанд байршуулах 151 мэдээллээс, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 гүйлгээг байршуулаагүй мөн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.2-д "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэсэн заалтуудыг тус тус бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:


1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газар-т ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г. Манлайжав, нягтлан бодогч Н. Нямдулам нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГАЗРЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

"ОЛ ДӨШ ХАЙРХАН АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Б.ЭНХЖИН

Ц.БУМЦЭНД

